



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багц) барьж ашиглалтад оруулсан, нийт 5,772,047,612.00 (таван тэрбум долоон зуун далан хоёр сая дөчин долоон мянга зургаан зуун арван хоёр) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан эзэмшигчийг тогтоох, хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001417
14-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
294... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ(ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Бүртгэх асуудлыг шийдвэрлэх байгууллага
					огноо	дугаар	
1	Залуучуудын хөгжлийн ордоны барилга (Тэнхлэгээрээ 18м x 12м бүхий зоорьтой 2 давхар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум 4 дүгээр баг)	м.кв	650	1,953,014,060	12/23/2024	ББКД-0005/2024	Сэлэнгэ аймаг Орон нутгийн өмчийн газар (Залуучуудын хөгжлийн ордоны барилга Сэлэнгэ аймгийн Сайхан сум 4 дүгээр баг)
2	Гадна холбоо, цэвэр ус, бохир, дулаан, цахилгаан	у/м	247	99,020,182.00			
3	Гадна цахилгаан шугам	м	300	82,323,861.00			
4	Ариутгах татуургын шугамын ажил	м	290	94,688,984.00			
5	Ногоон байгууламж, тохижилт	м.кв	725	141,049,124.00			
хэсгийн дүн				2,370,096,211.00			
6	Иргэдийн хөгжлийн төвийн барилга (Тэнхлэгээрээ 15м x 18м бүхий зоорьтой 3 давхар, Хан-Уул дүүрэг 16 дугаар хороо)	м.кв	1080	2,598,076,227	12/25/2024	БА-260/2024	Нийслэл өмчийн харилцааны газар (Иргэдийн хөгжлийн төвийн барилга Хан-Уул дүүрэг 16 дугаар хороо)
7	Гадна холбоо, цэвэр ус, бохир, цахилгаан	у/м	1747	734,353,226			
8	Ногоон байгууламж, тохижилт	м2	374	69,521,948			
хэсгийн дүн				3,401,951,401.00			
Нийт дүн				5,772,047,612.00			
				(таван тэрбум долоон зуун далан хоёр сая дөчин долоон мянга зургаа зуун арван хоёр)			